

**ХАРХОРУМ ХОТЫН ТӨЛӨВЛӨЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ““ОРХОНЫ ХӨНДИЙД “ШИНЭ  
ХАРХОРУМ” ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, ““ХОТ БАЙГУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, ““МОНГОЛ  
УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”,  
““МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, ““МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 01 дүгээр  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан ““Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, ““Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, ““Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, ““Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, ““Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулан 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурал 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслүүдийн хэлэлцэх үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гарагүй тул Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-т заасныг баримтлан тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсандаа баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

**“Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот  
байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд  
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоолын гарчиг, мөн тогтоолын 1, 2 дахь заалт, 2 дахь заалтын 1, 2, 3 дахь дэд заалтын “Шинэ” гэснийг тус тус хассугай.

2.Энэ тогтоолыг Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

### “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолын 13 дахь заалтын “зохицуулалтыг” гэсний дараа “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмсүгэй.

2.“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолын 1 дэх заалтын хүснэгтийн “Нэг.Улсын зэрэглэлтэй хот” гэсэн хэсгийн 4 дэх мөрний “Шинэ Хархорум” гэснийг “Хархорум хот” гэж өөрчилсүгэй.

3.Энэ тогтоолыг Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал  
батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын  
хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг  
үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол  
Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолын 1  
дүгээр хавсралтын 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.5, 3.1.6, 3.1.7, 3.1.8, 3.1.9, 3.1.10, 3.1.11, 3.2.21,  
3.3.19, 3.3.22, 3.4.22, 3.4.28, 3.4.33 дахь заалтын “Шинэ” гэснийг тус тус хассугай.

2.Энэ тогтоолыг Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг  
дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

**“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл  
ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг  
ундэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр  
батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21  
дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.3.1.1, 1.3.1.2, 3.3.2.7, 3.3.3.36 дахь заалтын  
“Шинэ” гэснийг тус тус хассугай.

2.Энэ тогтоолыг Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг  
дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө  
батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын  
хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг  
үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их  
Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолын 01 дүгээр  
хавсралтын 2.1.1.2, 2.1.1.3, 2.1.1.4, 2.1.1.5 дахь заалтын, мөн тогтоолын 2 дугаар  
хавсралтын “Төсөл, арга хэмжээ” баганын 2.3.2.4 дэх хэсгийн “Шинэ” гэснийг тус тус  
хассугай.

2.Энэ тогтоолыг Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг  
дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг